



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халиун сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413                      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:                      Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055                      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Аудитор:                                      П. Ганцолмон
	Утас: 70157405                      Цахим хаяг: <a href="mailto:ulistaivanaudit@gmail.com">ulistaivanaudit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	14
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	14
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХАЛИУН  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ О.ЦЭНДСҮРЭН ТАНАА

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒5 № 1᠒7

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халиун сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халиун сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020308

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	42,886,709.03	59,283,119.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31210	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	19,864.43	19,864.43
33500	Бусад авлага	19,864.43	19,864.43
33510	Байгууллагаас авах авлага	19,864.43	19,864.43
35	БАРАА МАТЕРИАЛ	(42,866,844.60)	(26,470,434.60)
35100	Түүхий эд материал	-	(30,000.00)
35110	Тусгай зориулалттай материал	1,650,000.00	1,650,000.00
35130	Эм боох материал	50,000.00	20,000.00
35400	Хангамжийн материал	(0.00)	16,426,410.00
35410	Бичиг хэргийн материал	48,000.00	256,500.00
35420	Аж ахуйн материал	29,619,844.60	30,221,144.60
35440	Түлш, шатах тослох материал	656,000.00	164,000.00
35450	Барилгын засварын материал	10,484,000.00	11,914,000.00
35460	Хүнсний материал	84,000.00	3,296,210.00
35470	Бусад хангамжийн материал	275,000.00	11,741,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	85,606,935.33	62,503,935.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	(85,606,935.33)	(108,709,934.96)
39200	Биет хөрөнгө	(0.00)	(23,030,999.63)
39201	Барилга, байгууламж, орон сууц	132,414,466.21	142,333,966.21
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(90,721,268.00)	(120,550,708.36)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	48,543,487.00	54,188,487.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(20,948,183.50)	(28,436,049.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,443,605.50	34,327,605.50
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(21,651,392.31)	(26,813,585.22)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,016,975.43	1,016,975.43
39217	Номын фонд	1,171,245.00	1,171,245.00
39300	Биет бус хөрөнгө	-	(72,000.00)
39301	Програм хангамж	720,000.00	720,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(382,000.00)	(454,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	128,493,644.36	121,787,054.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	128,493,644.36	121,787,054.73
51	Засгийн газрын хувь оролцоо	128,493,644.36	121,787,054.73
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	98,427,256.36	98,427,256.36
51200	Хуримтлагдсан үр дүн	(156,903,925.38)	(163,610,515.01)
51210	Өмнөх үеийн үр дүн	(156,903,925.38)	(156,903,925.38)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(6,706,589.63)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	186,970,313.38	186,970,313.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	128,493,644.36	121,787,054.73

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэл	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	238,360,700.00	229,453,880.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,213,500.00	83,280.00
1200	Нийтлэг татварын бус орлого	17,213,500.00	83,280.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,213,500.00	83,280.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,213,500.00	83,280.00
1220	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1,000,000.00	-
122001	Хандив тусламж-дотоод	1,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	220,147,200.00	229,370,600.00
1310	Удсын төсвөөс	220,147,200.00	229,370,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,503,800.00	32,977,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	189,643,400.00	196,392,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	245,507,811.51	236,160,469.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,507,811.51	236,160,469.63
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	218,989,349.02	225,558,920.91
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	136,059,658.08	132,855,145.12
210101	Үндсэн цалин	126,215,793.08	123,608,081.12
210104	Урамшуулал	9,843,865.00	9,247,064.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,709,703.89	17,045,879.16
210201	Тэтгэврийн даатгал	12,841,506.75	11,278,780.76
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,724,828.97
210203	ҮОМЦӨ-ний даатгал	1,031,624.98	1,082,409.13
210204	Ажилгүйдлийн даатгал	257,208.66	253,837.56
210205	Эрүүл мэндийн даатгал	2,579,363.50	2,706,022.74
2103	Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал	19,610,191.11	19,850,672.00
210301	Гэрэл, цамилгаан	924,510.11	1,000,584.00
210302	Түлш, хялаалт	18,479,181.00	18,770,088.00
210303	Цэвэр, бөмр ус	206,500.00	80,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,012,320.00	3,706,715.00
210401	Бичиг хэрэг	419,920.00	367,750.00
210402	Тээвэр, шатахуун	627,700.00	1,917,465.00
210403	Шуудан, хөлбоо, инпернэтийн төлбөр	250,000.00	250,000.00
210404	Ном, хэвлэл	-	98,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	494,700.00	952,900.00
2105	Нормативт зардал	8,682,220.00	6,333,410.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	130,500.00	630,000.00
210502	Хоол, хүнс	8,551,720.00	5,670,010.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	33,400.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	912,400.00	2,000,600.00
210604	Урсгал засвар	912,400.00	2,000,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544,000.00	1,068,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	420,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,458,855.94	42,698,499.63
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дэдлага хийх	287,000.00	147,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хөрөгдөл	34,171,855.94	42,551,499.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,518,462.49	10,601,548.72
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт	331,844.46	269,128.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	331,844.46	269,128.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,334,118.03	9,452,420.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,334,118.03	9,452,420.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	852,500.00	880,000.00
213209	Нэг удаагийн гэтгэмж, шагнал урамшуулал	852,500.00	880,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(7,147,111.51)	(6,706,589.63)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI-III-IV-V)	(7,147,111.51)	(6,706,589.63)

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	98,427,256.36	186,970,313.38	(156,903,925.38)	128,493,644.36
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,427,256.36	186,970,313.38	(156,903,925.38)	128,493,644.36
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,706,589.63)	(6,706,589.63)
16	ҮЛДЭГДЭЛ	98,427,256.36	186,970,313.38	(163,610,515.01)	121,787,054.73

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/Төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	220,147,200.00	229,370,600.00		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	220,147,200.00	229,370,600.00		
1310	Улсын төсвөөс	220,147,200.00	229,370,600.00		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,503,800.00	32,977,900.00		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	189,643,400.00	196,392,700.00		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	220,147,200.00	209,922,100.00		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,147,200.00	209,922,100.00		
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,628,737.51	199,320,551.28		
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	136,059,658.08	132,855,145.12		
210101	Үндсэн цалин	126,215,793.08	123,608,081.12		
210104	Урамшуулал	9,843,865.00	9,247,064.00		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,709,703.89	17,045,879.16		
210201	Тэтгэврийн даатгал	12,841,506.75	11,278,780.76		
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,724,828.97		
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,031,624.98	1,082,409.13		
210204	Ажилгүйдлийн даатгал	257,208.66	253,837.56		
210205	Эрүүл мэндийн даатгал	2,579,363.50	2,706,022.74		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,121,055.54	19,358,672.00		
210301	Гэрэл, цахилгаан	944,374.54	1,000,584.00		
210302	Түлш, халаалт	18,970,181.00	18,278,088.00		
210303	Цэвэр, бохир ус	206,500.00	80,000.00		
2104	Хангамж, бараа материалын зардал	1,849,220.00	3,809,015.00		
210401	Бичиг хэрэг	256,820.00	423,250.00		
210402	Тээвэр, шатахуун	627,700.00	1,917,465.00		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	250,000.00		
210404	Ном, хэвлэл	-	98,600.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	120,000.00		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	494,700.00	999,700.00		
2105	Нормативт зардал	7,853,100.00	20,532,240.00		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	130,500.00	600,000.00		
210502	Хоол, хүнс	7,722,600.00	8,798,940.00		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	11,133,300.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,050,900.00	3,901,600.00		
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-		
210602	Тавилга	-	471,000.00		
210604	Урсгал засвар	10,050,900.00	3,430,600.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544,000.00	1,068,000.00		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	420,000.00		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	441,100.00	750,000.00		
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	441,100.00	750,000.00		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,518,462.49	10,601,548.72		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	331,844.46	269,128.00		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	331,844.46	269,128.00		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,334,118.03	9,452,420.72		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,334,118.03	9,452,420.72		
2132	Бусад урсгал шилжүүлэг	852,500.00	880,000.00		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	852,500.00	880,000.00		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	19,448,500.00		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	19,448,500.00		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	19,448,500.00		
223	БУСАД ХӨРӨНГӨ	-	19,448,500.00		
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	19,448,500.00		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	(19,448,500.00)		
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-		
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл
		Батлагдсан төлөвлөгөө	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	229,370,600.0	219,649,051.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	229,370,600.0	219,649,051.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	228,410,600.0	218,769,051.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	138,309,500.0	132,855,145.12
210101	Үндсэн цалин	125,939,000.0	123,608,081.12
210104	Урамшуулал	12,370,500.0	9,247,064.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,511,700.0	17,045,879.16
210201	Тэтгэврийн даатгал	14,012,700.0	11,278,780.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,625,000.0	1,724,828.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,300,000.0	1,082,409.13
210204	Ажилгүйдлийн даатгал	325,000.0	253,837.56
210205	Эрүүл мэндийн даатгал	3,249,000.0	2,706,022.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,577,900.0	19,358,672.00
210301	Гэрэл, цахилгаан	1,090,000.0	1,000,584.00
210302	Түлш, халаалт	18,287,900.0	18,278,088.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	80,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,842,000.0	3,809,015.00
210401	Бичиг хэрэг	450,000.0	423,250.00
210402	Тээвэр, шатахуун	1,922,000.0	1,917,465.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.0	250,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.0	98,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу	120,000.0	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.0	999,700.00
2105	Нормативт зардал	20,558,100.0	20,532,240.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,000.0	600,000.00
210502	Хоол, хүнс	8,824,500.0	8,798,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,133,600.0	11,133,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,400,000.0	23,350,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.0	5,000,000.00
210602	Тавилга	5,000,000.0	5,000,000.00
210604	Урсгал засвар	13,400,000.0	13,350,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,461,400.0	1,068,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	813,400.0	420,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.0	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	750,000.0	750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.0	750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,000.00	880,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	960,000.0	880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,000.0	880,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	229,370,600.0	219,649,051.28
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	196,392,700.0	186,940,279.28
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	196,392,700.0	186,940,279.28
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,977,900.0	32,708,772.00
132001	Орон нутгийн төсвөөс	32,977,900.0	32,708,772.00

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Халиун сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Улиастай ван аудит" ХХК-ийн аудитор П. Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Халиун сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус цэцэрлэг нь 2021-2022 оны хичээлийн жилд хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, хоцрогдолгүй сургах,багшийн хөгжлийг хангах боломжийг бүрдүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчныг бүрдүүлж ажиллах зорилго тавьсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.


Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ



Говь-Алтай аймгийн Халиун сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 194.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 236.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр шинэчлэн тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Халиун сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.2 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59.3 сая төгрөг болж 16.4 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйг материал, барилгын засварын материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 28.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 12.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 238.8 сая төгрөг болж 19.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 121.8 сая төгрөг болж 6.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 3.7 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -163.6 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 242.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 13.2 сая төгрөгөөр бууруулж, 229.4 сая төгрөгөөр баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 229.4 сая төгрөгийн төсөв баталснаас 196.4 сая төгрөгийг улсын төсвөөс 33.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 196.4 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөг нийт 229.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 219.6 сая төгрөгийг зарцуулж 9.5 сая төгрөгийг улсын төсөвт, 0.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 219.6 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 5.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлыг 0.4 сая төгрөгөөр, бусад урсгал шилүүлгийг 0.1 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлан онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 142 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 6 мэдээлэл мэдээллээгүй 3 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. 2021 оны 318.9 сая төгрөгийн 22 мэдээллийг ил тод байршуулахаас 318.9 сая төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ

Худалдан авалтын 3.2 сая төгрөгийн төгрөгийн гүйлгээг и баримтгүй хийснийг аудитын явцад нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дээрх зөрчлийг залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 7.1 сая төгрөгийн албан шаардлага биелүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.2 сая төгрөгийн алдааг залруулж 1.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ

#### 4.1 Залруулсан алдаа

Худалдан авалтын 3.2 сая төгрөгийн гүйлгээг и баримтгүй хийснийг аудитын явцад нөхөн шивүүлсэн

#### 4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй.

#### 4.3 Албан шаардлага

- Татварын тодорхойлолтоор 0.08 сая төгрөгийн дутуу, 0.01 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар "43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй 1.6 сая төгрөгийн зарлага гаргасан нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд 19.6 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ,14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1,тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Халиун сумын хүүхдийн цэцэрлэг	4	24.4	1	1.6	0	0	3	22.8	0	0

Аудитын код: ГАА-2022/128/-НА-СТА-ТШЗ